



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/105

Есөнбулаг сум

Салбар зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, "Аэродром орчимд агаарын хөлгийг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх" MNS 6942:2021 стандартын 5.7.2 дахь заалт, "Агаарын хөлөг, шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журам"-ын 2.13, 2.14, 3,6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг дахь "Агаарын хөлөг, шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэх баталсугай.

Зөвлөлийн дарга:

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

(Есөнбулаг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч)

(Есөнбулаг сумын газрын даамал)

(Алтай нисэх буудлын нислэгийн хөдөлгөөний удирдагч)

(Алтай нисэх буудлын аэродромын инженер)

(Алтай нисэх буудлын Шувууны хяналтын ажилтан)

(Авиа компанийн төлөөлөгч нар)

Нарийн бичгийн дарга: (Алтай нисэх буудлын дарга)

2.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандарт баталсан журмын дагуу зохион байгуулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн уялдаа холбоо, оролцоог хангуулан зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3.Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлөөс гарсан шийдвэр, ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/118 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



D:zahiramjZax.ZD 2025
8200010120

